



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Нийслэлийн Цагдаагийн газрын данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/172 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 202,498,831 /хоёр зуун хоёр сая дөрвөн зуун ерэн найман мянга найман зуун гучин нэгэн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан 12 тээврийн хэрэгслийг актлаж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Цагдаагийн газар /Д.Ядамдорж/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Нийслэлийн Цагдаагийн газар /Д.Ядамдорж/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Х.Жаргалсайхан/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс /Д.Итгэл/-т тус тус даалгасугай.

ДАРГА  Ч.ОДНАСАН
ТТА-2371

115050000187

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 2019 оны 03 дугаар сарын 13 -ны өдрийн
 А/46 дугаар тушаалын хавсралт

СЭЛБЭГИЙН БУЮУ ХОЕРДОГЧ ТҮҮХИЙ ЭДИЙН ЗОРИУЛАЛТААР ТАТАН
 ТӨВЛӨРҮҮЛЖ ХУДАЛДАХААР ШИЙДВЭРЛЭГДСЭН
 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛҮҮД

/төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Марк, дугаар	Нийт гүйлт мян.км	Баланс үнэ	Үйлддвэрлэгдсэн он	Байгуулаг-дсан элэгдэл	Үлдэгдэл үнэ
1	Нийслэлийн Цагдаагийн газар	Уаз-31512 40-73 УБЗ	143365	13,293,100	2008/2008	13,293,100	-
2		Уаз-31512 24-44 УБА	204342	4,800,000	2003/2003	4,800,000	-
3		Уаз-31512 17-46 УБЛ	298875	8,500,000	2005/2005	8,500,000	-
4		Уаз-31512 40-44 УБЗ	153727	13,293,100	2008/2008	13,293,100	-
5		Уаз-31512 40-70 УБЗ	182791	13,293,100	2008/2008	13,293,100	-
6		Шевролет Авио 40-55 УНБ	77711	19,368,000	2009/2009	19,368,000	-
7		Шевролет Авио 40-53 УНБ	111948	19,368,000	2009/2009	19,368,000	-
8		Шевролет Авио 40-63 УНБ	171089	19,368,000	2009/2009	19,368,000	-
9		Шевролет Авио 40-68 УНБ	117105	19,368,000	2009/2009	19,368,000	-
10		Ландкрузер 13-17 УББ	328187	28,000,000	1996/2004	28,000,000	-
11		Faw CA6750 31-13 УБИ	124650	23,162,000	2006/2007	23,162,000	-
12		IVECO BSX5040 40-71	92427	20,685,531	2008/2008	20,685,531	-
Нийт дүн				202,498,831		202,498,831	